



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН  
УЛААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2024 оны 07 сарын 24 өдөр

Дугаар А/69

Төгөл

**Урамшуулал олгох тухай**


Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Төрийн албаны тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1.4 дэх заалт, Нягтлан бодох бүртгэлийн бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дах хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дугаар зүйлийн 14.2.3 дах хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.4.2 дах хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Тус сумын Эрүүл мэндийн төвийн Их эмч Батмөнхийн Сарнайд Эрүүл мэндийн салбарын Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2023 оны жилийн эцсийн санхүү, төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан гарсантай холбогдуулан санхүүгийн тайлангийн нэгтгэлд хамрагдсан "Өөрчлөлтгүй" дүгнэлт авсан тул нэг сарын үндсэн цалингийн 100 хуваар тооцон урамшуулал олгосугай.

2.Уг урамшууллыг 2024 оны 07 дугаар сард журмын дагуу тооцож олгохыг нягтлан бодогч (Б.Баярмаа)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын үнэлгээ тайланг санхүүгийн албанд тушаахыг Эрүүл мэндийн төвийн дарга (Б.Нарангарвуу)-д үүрэг болгосугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Тамгын газрын дарга (М.Батцогт)-д үүрэг болгосугай.

ДАРГА  Н.БАТБАЯР



/Zahiramj/